



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 13 өдөр

Дугаар A/56.

Улаанбаатар хот

Г Аялал зохион байгуулах тухай Т


Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар дугаар зүйлийн 16.4.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 75 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/520 дугаар захирамж, тус газрын дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэл Улаанбаатар хотын 375 жилийн ойг тохиолдуулан оюутан сурагчид, тохижилт үйлчилгээний ажилтнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулсан Улаанбаатар хотын үйлдвэр, соёлын газруудтай танилцуулах аяллыг 2014 оны 10 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулахыг ахлах мэргэжилтэн /Д.Ганболд/, Хот орчмын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн /Б.Ербахыт/ нарт тус тус даалгасугай.
2. Хотын аялал зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Арга хэмжээ зохион байгуулахад шаардагдах төсөв 5,010,000 /таван сая арван мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Э.БАТТУЛГА





Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2014 оны 10 сарын 28-ндийн  
тоот тушаалын нэгдүгээр хавсралт

## НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН 375 ЖИЛИЙН ОЙН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОТЫН АЯЛЛЫН УДИРДАМЖ

2014.10.13

Улаанбаатар хот

НЭГ. ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

Нийслэл хотын иргэд, залууст тэдний өдөр тутам хэрэглэдэг цэвэр ус, дулаан, цахилгааныг хэрхэн үйлдвэрлэж, ямар дамжлага, замаар хүргэдэг, яагаад зүй зохицой ашиглах ёстой талаар танилцуулах, Улаанбаатар хотын түүх, соёл, аялал жуулчлалын үзмэрүүдийг таниулах, хотын соёл, хотын иргэний талаарх ойлголтыг төлөвшүүлэх, нийслэл хотоороо бахархах ухамсар, ойлголтыг өгөхөд энэхүү аяллын зорилго оршино.

### ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, аялал жуулчлалын чиглэлээр сурдаг их сургуулийн 1-р дамжааны оюутнууд, нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэлийн тохижилт үйлчилгээний ажилтнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчдөөс бүрдсэн 4 аяллын баг өөр чиглэлээр аялалд оролцно.

### ГУРАВ. АЯЛЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Улаанбаатар хоттой танилцах аяллыг 2014 оны 10 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулна. Аяллын 4 баг тус бүр дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

1-р баг: Ерөнхий боловсролын сургуулийн дунд/ахлах ангийн 32 сурагч, НИТХ-ын 3 төлөөлөгч, хэвлэл мэдээллийн 5 ажилтан Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 3 мэргэжилтэн, хөтчийн хамт нийт 44 хүний бүрэлдэхүүнтэй

2-р баг: Аялал жуулчлалын чиглэлээр суралцаж байгаа 32 оюутан, НИТХ-ын 3 төлөөлөгч, хэвлэл мэдээллийн 5 ажилтан Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 3 мэргэжилтэн, хөтчийн хамт нийт 44 хүний бүрэлдэхүүнтэй

3-р баг: Улаанбаатар нэгтгэлийн 32 ажилтан, НИТХ-ын 3 төлөөлөгч, хэвлэл мэдээллийн 5 ажилтан Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 3 мэргэжилтэн, хөтчийн хамт нийт 44 хүний бүрэлдэхүүнтэй

4-р баг: Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон харгалзан явах хүмүүсийн хамт 32 хүн НИТХ-ын 3 төлөөлөгч, хэвлэл мэдээллийн 5 ажилтан Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 3 мэргэжилтэн, хөтчийн хамт нийт 44 хүний бүрэлдэхүүнтэй.

Аялал эхлэхийн өмнө Хүрээ соёл буюу хотын соёлын чиглэлээр нэг цагийн танилцуулга зохион байгуулна.

#### ДӨРӨВ. АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ

Нийслэлийн өдрийг тохиолдуулан сургач, оюутан залуус, ажилтан албан хаагч, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг Улаанбаатар хотын үйлдвэр, соёлын газруудтай танилцуулах аяллын зардлыг Нийслэлийн Засаг Даргын 2014 оны 06-р сарын 20-ны өдрийн захирамжийн дагуу батлагдсан хөрөнгөөс гаргана.

#### ТАВ. АЯЛЛЫН ЧИГЛЭЛҮҮД

##### Нэгдүгээр чиглэл. “Дулааны 4-р цахилгаан станц”

- Хариуцах: Нийслэлийн Аялал Жуулчлалын Газрын Маркетинг, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн М.Болортuya, 70108687, 91208639
- Аяллын хөтөч: Улаанбаатар хотын музейн эрдэм шинжилгээний ажилтан Г.Очбаяр

##### Хоёрдугаар чиглэл. Хүнсий үйлдвэртэй танилцах

- Хариуцах: Нийслэлийн Аялал Жуулчлалын Газрын дотоод аялал хариуцсан мэргэжилтэн Н.Алтанзаяа, 70108687, 96076064
- Аяллын хөтөч: Чингис хаан дээд сургуулийн багш, түүхч О.Сүхбаатар 99742000

##### Гуравдугаар чиглэл. “Ус сувгийн удирдах газрын сургалтын төв”

- Хариуцах: Нийслэлийн Аялал жуулчлалын газрын Мэдээлэл, сурталчилгааны төвийн менежер Д.Энхбаяр 70108687
- Аяллын хөтөч: Монгол улсын нэгдүгээр зэрэгтэй хөтөч А.Цэрэнчулун

##### Дөрөвдүгээр чиглэл. “Цахилгаан тээвэр”

- Хариуцах: Нийслэлийн Аялал жуулчлалын газрын Хот орчмын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн Б.Ербахыт 99413120, 70128687
- Аяллын хөтөч: Гараг студын захирал, сэтгүүлч Г.Бадамсамбуу